

**ХЭРЛЭНТОХОЙ ХХVIII ТАЛБАЙД БҮТЭЭГДЭХҮҮН
ХУВААХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ГАЗРЫН ТОСНЫ
ХАЙГУУЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТӨСЛИЙН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ГАРЧИГ

1.1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
1.2. ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН “ХЭРЛЭНТОХОЙ ХХVIII” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
2.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙД БАЙРЛАЖ БУЙ СУМД	5
2.2. ДЭД БҮТЭЦ, ЗАМ ХАРИЛЦАА	5
2.3. УУР АМЬСГАЛ	5
2.4. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙН ТОГТОЦ	6
2.5. УСАН ОРЧИН	7
2.6. ХӨРСӨН БҮРХЭВЧ	10
2.7. УРГАМЛЫН АЙМАГ	10
2.8. АМЬТНЫ АЙМАГ	11
2.9. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ	11
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИХ ҮЕД ХИЙГДЭХ АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ.....	13
3.1. ТӨСЛИЙН ЗОРИЛГО	13
3.2. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	13
3.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ МЭДЭЭЛЭЛ	13
3.4. ТӨСӨЛД АШИГЛАГДАХ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ.....	13
3.5. УСНЫ ХЭРЭГЛЭЭ.....	14
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	16
4.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	16
4.2. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	16
4.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	17
4.4. АМЬТАН, УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	17
БҮЛЭГ 5. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	18
БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
БҮЛЭГ 8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ ..	23
БҮЛЭГ 10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	27
БҮЛЭГ 13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	29
БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ 15. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ НИЙТ ЗАРДАЛ	31

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршил зураг.....	3
Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч.....	10
Зураг 3. Талбайн ургамалжилт.....	11
Зураг 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн зураг.....	12
Зураг 5. Төслийн үед ашиглагдах техник, технологи.....	14

Хүснэгтийн жагсаал

Хүснэгт 1. Усны хэрэглээ.....	15
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	19
Хүснэгт 3. Тэрбум модны хөдөлгөөний ажлыг гүйцэтгэх зардлын тооцоо.....	22
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоо.....	23
Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	23
Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ.....	24
Хүснэгт 7. Осол эрсдэлээс үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ.....	25
Хүснэгт 8. Хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ.....	27
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн давтамж, зардал.....	29
Хүснэгт 10. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	30

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

“Монголиа Фойсон Энержи” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 137 дугаар тогтоолоор эрх олгогдсоны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны газартай Хэрлэнтохой ХХVIII талбайд газрын тосны хайгуул хийх Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан.


Тус компани 2025 онд 13,364 км² талбайд геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэж, нийт 7,318 физик цэгт хүндийн хүчний судалгаа, 6,738 тууш км хэмжээтэй талбайд соронзон хайгуулын судалгаа хийсэн. Харин 2026 онд хайгуулын нэг цооног өрөмдөхөөр төлөвлөн ажиллаж байна.

Эрхэм зорилго

Газрын тосны хайгуулын ажлын үр дүнгээр Монгол улсад газрын тосны эдийн засгийн үр ашигтай орд газар нээх.

1.2. ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН “ХЭРЛЭНТОХОЙ ХХVIII” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Засаг захиргааны хувьд Дорнод аймгийн Матад сумд болон Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших бөгөөд нийт 13875 га талбайг хамарна. Хайгуулын ажлын нийт талбай нь Улаанбаатар хотоос 675 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос 157 км, Сүхбаатарын Баруун урт хотоос 107 км, далайн түвшнээс дээш 626 м-1055 м өндөрт байрлана.



Зураг 1. Хэрлэнтохой ХХVIII талбайн байршлын зураг

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дорнод аймаг нь Монгол улсын хамгийн зүүн хязгаарт оршдог 124000 км² газар нутагтай бөгөөд хэмжээгээрээ аймгуудаас эхний гуравт ордог. Дорнод аймгийн хүн ам одоогийн байдлаар 86.1 мян. Халх, буриад, барга, үзэмчин үндэстэн ястангууд оршин суудаг. Засаг захиргааны нэгжийн хувьд 14 сум 67 багтай. Нийт хүн амын 55 хувь нь Зүүн бүсийн хөгжлийн тулгуур төв, Цэргийн гавьяаны одонт аймгийн төв Чойбалсан хотод амьдардаг. Дорнод аймаг нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр аймгуудаас 3-р байранд орж байна.

2.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙД БАЙРЛАЖ БУЙ СУМД

Матад сум: Тус сум 22.2 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, 2334 хүн амтай, 63.254 толгой малтай. Үүнээс тэмээ 982, адуу 11.768, үхэр 916, хонь 26.792, ямаа 14.544 толгой байна. Засаг захиргааны нэгжийн хувьд Жаргалант, Баянхангай, Түмэнхаан, Буянөндөр, Мэнэн, Эрдэнэбадрах гэсэн 6 багтай. Сумын төв Зүүнбулаг нь аймгийн төвөөс 150 км зайд байрладаг. Зүүн өмнөд ба хойд хэсгээрээ БНХАУ-тай өмнөд ба баруун хэсгээрээ Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдтай, бусад талаараа Булган, Баянтүмэн, Халхгол сумтай хиллэдэг.

2.2. ДЭД БҮТЭЦ, ЗАМ ХАРИЛЦАА

2026 оны газрын тосны хайгуулын өрөмдлөгийн ажлыг Дорнод аймгийн Матад сумын нутагт аймгийн төвөөс зүүн урагш 100 орчим км Өглөгийн хотор орчмоор хийхээр төлөвлөж байна. Тус газар нь орон нутгийн шороон замтай, эрчим хүч болон харилцаа холбооны 3G, 4G LTE сүлжээнд холбогдоогүй хээр газар болно.

2.3. УУР АМЬСГАЛ

Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт орших Хэрлэнтохой XXVIII талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах талбай, түүний эргэн тойрны бэсрэг болон бичил бүс нутаг нь эх газрын эрс тэс хахир ширүүн уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтийн шинж нь тэгш хэмийн 4 улирлын хуваарилалттай. Хуурайсуу сэрүүн, хүйтэн уур амьсгалын ангилалд хамрагдана. Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн дундаж агаарын температур нутгийн баруун хойд болон зүүн хэсгээрээ -2.0-0.0°C, төв хэсгээр +2.0-+4.0°C байх бөгөөд бусад талбайгаар 0.0-+2.0°C байдаг. Харин жилийн нийлбэр хур тунадас нутгийн баруун хойд болон зүүн хэсгээр 310-400 мм, төвийн хэсгээр 200-250 мм байх бөгөөд бусад талбайгаар 300-350 мм унадаг байна. Дорнод аймгийн уур амьсгалын ерөнхий хандлагыг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-ийн 2005-2023 оны буюу 16 жилийн мэдээг ашиглан боловсруулав. Дорнод аймгийн жилийн агаарын дундаж температур нь жил бүр харилцан адилгүй хэлбэлзэж байгаа ч цаашид нэмэгдэх хандлагатай байна. Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 2012 онд +0.2°C, хамгийн дулаан жил 2007 онд +3.6°C хүрч байжээ. 2005 оноос 2016 оны агаарын дундаж дулааны утгуудыг 2017-2023 оны утгатай харьцуулахад 2017-2023 оны агаарын дундаж дулаан нь харьцангуй тогтвортой харагдаж байна. Тус нутгийн мэдээллийг үзэхэд жил бүрийн хур тунадас нь харилцан адилгүй, ихээхэн өөрчлөлттэйгээр ордог бөгөөд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 140.7-428.6 мм-ийн хооронд хэлбэлзсэн байна. Тус нутгийн газрын гадарга ихэвчлэн жигд талархаг учир дулаан хүйтний ялгаа багатай, агаарын олон жилийн дундаж температур нь Чойбалсан хотод -3.5°C-+4°C хооронд харин Баруун-Урт хотод -3.9-+4.7 хооронд, өөрөөр хэлбэл жилүүдийн дундаж температурын агууриг 0.95-1.07°C байна.

Жилийн хамгийн хүйтэн сар нь нэгдүгээр сар бөгөөд Чойбалсан хотод агаарын дундаж температур нь (-41°C), Матад сум болон Баруун-Урт хотод (-36°C) хүрч хүйтэрнэ. Эндээс нутгийн хойд зүгээс урд зүг илүү дулаавтар 5 градусаар дулаан байна. Хамгийн дулаан сар нь долдугаар сар бөгөөд Чойбалсан хотод агаарын дундаж температур нь $+41^{\circ}\text{C}$, Матад болон Баруун-Уртад $+40^{\circ}\text{C}$, хамгийн их температурын дундаж нь $+46^{\circ}\text{C}$ хүрнэ. Жилд $+10$ градусаас дулаан байх өдөр 120-150 Жил бүр $+30^{\circ}\text{C}$ -ээс ба түүнээс дээш температуртай өдрийн тоо нь 10-30 өдрийн хооронд хэлбэлздэг. Хоногийн дундаж агаарын температур 4 сарын 10-аас дараа жилийн 10 сарын 17 хүртэл 0°C -аас дулаан 170 хоног 1550 градус дулаан хуримтлагддаг. Үлдсэн хугацаанд 0 градусаас бага хүйтэн -2452 градус хуримтлагдана. Нарны жилд гийгүүлэх хугацаа нь Чойбалсан хотод 2700-3000 цаг байхад урагшлах тусам 3000-3200 цаг болж нэмэгдэнэ. Чойбалсан хот, Матад, Сүхбаатар хотын Баруун-Урт хотын температурыг харьцуулахад Чойбалсан хот нь илүү дулаан ба Сүхбаатар хотын Баруун-Урт хотын нутаг нь илүү сэрүүвтэр байна.

Элсний нүүлт хөдөлгөөнд нөлөөлөх байгалийн хүчин зүйлээс салхины горим, тухайлбал салхины зүг чиг, давтагдал, хурд зонхилох нөлөөтэй. Салхи нь цаг хугацаа, орон зайн хувьд байнга өөрчлөгдөж байдаг тогтворгүй хэмжигдэхүүн бөгөөд салхины цаг уурын станцын мэдээг ашиглав.

2022 оны 04 дүгээр сард сумдын бүх нутгаар салхины их хурд 12-23 м/сек хүрч салхилсан байна. Чойбалсан, Дашбалбар, Матад, Халхгол, Баян-Уул, Баяндун, Баянтүмэн, Ялалт баг, Чулуунхороот сумдын нутгаар 10-26 өдөр, бусад сумдаар 5-8 өдөр 10 м/сек салхитай байсан ба 15 м/сек-ээс дээш их салхи Чойбалсан, Дашбалбар, Матад, Халхгол, Баян-Уул, Баяндун, Гурванзагал, Цагаан-Овоо, Чулуунхороот сумдад ажиглагдсан байна.

2.4. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙН ТОГТОЦ

Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт орших Хэрлэнтохой XXVIII талбай нь тэгш газар, нам толгод сондуул, тэдгээрийн хоорондийн тэгш газар бүхий тал нутаг зонхилно. Монгол орны фицик газарзүйн мужлалаар Монголын Дорнод талын их мужид хамаарна. Талбайн ихэнхи нутаг нь Дорнодын тэгш талын мужийн Тамсагийн тал, харин урд захаар Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Халхын дундад ухаа гүвээт тал орно.

Төслийн талбайн хойд зах Хэрлэн голын наагуур өнгөрнө. Жаргалант уул 861 м, Очирт толгой, Сэрвэн толгой, Ээнчин толгой, Шар өндөр толгой, Хөх өндөр толгой, Даруулга уул, Баян уул, Шинэ толгой, Даянтолгой, Болдог овоо, Цагаан уул гэх мэд уулс байна. Тус нутгийн өндөршил нь Далайн түвшнээс дээш 600-1100 м хооронд ба баруунаас зүүн тийш намсана. Хамгийн өндөр уул Баршил уул нь 1097м юм.

Судалгааны талбай нь геоморфологийн ангиллаар Дорнод Монголын талын мужид хамаарагдаж (Сырнев бусад 1982) түүний дунд хэсэгт байрлана. Дорнодын талын геоморфологийн тогтоцын талаар Мурзаев (1952), Селиванов (1972), Сырнев (1982) нарын ном өгүүлэлүүдэд дурьдсан байдаг. 1:20000 масштабын геологийн зураглал хийсэн талбайд ерөнхийдөө тэгш тал, нам уулсын гадаргуу (рельеф) зонхилдог юм. Эдгээрийг гарал үүсэл, дүрс хэлбэрийн төрлүүдээр ангилан 1:500 000 масштабын геоморфологийн тойм зохиосон болно.

Судалгааны талбайд ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий үлдмэл уулс, уулс хоорондын ба уулан дундах хотгор, голын хөндий дэх хурмал хурдаст хотос гадарга (N^2-Q^1 , Q), тэгширмэл газар,

уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай. өргөгдмөл гадарга (Mz-Q), дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн давхаргат тал гарал үүслийн төрлүүдийг ялгаж байна. Гадаргуугийн гарал үүслийн төрөл тус бүр нь өөртөө тодорхой дүрс хэлбэрийн төрлүүдийг багтааж байдаг.

2.5. УСАН ОРЧИН

Газар доорх ус

1:200000-ны масштабтай геологийн зураглалын явцад судалгааны талбайн хэмжээнд тархсан уст цэгүүдийг нэг бүрчлэн судлаагүй бөгөөд зөвхөн цөөн тооны сорьц сонгон авч шинжлүүлээд түүний үр дүнг өмнөх судлаачдын тайлан, мэдээлэл болон нэгтгэсэн зургуудтай харьцуулан үзэв.

Судалгааны талбай нь гидрогеологийн мужлалаар Монголын дорнод хэсэгт хамаарагдана. Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт орших Хэрлэнтохой XXVIII талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхлэх төслийн талбайн хойд зах нь Хэрлэн голын урдуур өнгөрнө. Монгол Дорнод хэсгийн бүх гол горхийг түүний байршлаар Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах гол горхи болон Номхон далайн ай савд багтах гол гэж хоёр үндсэн ай савд хуваасанд төслийн талбай нь Номхон далайн ай савд багтана. Хэрлэн гол нь Номхон далайн ой савын Хэрлэнгийн савын голд багтана.


Хэрлэн голын сав газрын газрын доорх ус нь ихэнхдээ эрдэсжилт, хатуулаг багатай цэнгэг найрлагатай байдаг боловч азотын төрлийн ионоор бохирдсон, төмрийн ионоор баяжиж ундны усны стандартад заасан хэмжээнээс давах тохиолдол харьцангуй их байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Нуурууд

Дорнод бүсэд 300 гаруй нуур байх авч хатаж ширгэдэг жижиг хэмжээний нуурууд олонтой. Эдгээр жижиг нууруудын нийлбэр 390км² хүрнэ. Энэ бүсийн нуурууд Монгол орны нуурын газарзүйн ангиллаар талархаг нутгийн нуурын их мужийн хээрийн мужид багтана. Төслийн бүсэд Матад сумын нутагт Их халуун шаварт нуур, Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд Бүрдийн нуур мөн Дорнод аймгийн Булган, Матад, Баянтүмэн сум олон жижиг нууруудтай. Тэдгээр жижиг нуурууд нь томдоо 500-600 м өргөнтэй, 1000 м хүртэл урттай. Энэхүү жижиг нуурууд дээр тодорхой судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байна.

2.6. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Монголын дорнод талын их муж Тамсагийн талд хамаарагдаж байна. Халх гол орчмын өргөн уудам тал газарт гол төлөв элсэнцэр болон шавранцар хар хүрэн хөрс зонхилох бөгөөд эдгээр нь дотроо карбонаттай болон карбонатгүй гэсэн төрөлд хуваагдана. Хэрлэн голын эрэг захаар Сийрэг элсэн хүрэн хөрс, нугын мараалаг хөрс, толгодын хар хүрэн, нимгэн сайр чулуурхаг хар хүрэн, үлдмэл нугат хүрэн, мараалаг хүрэн болон мараа хужрын бүрдэл, нугат хар хүрэн, хужир марааны бүрдэл, нугат хүрэн болон хужир марааны бүрдэлтэй хөрс, нугат хөрс зонхилно.




Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч

2.7. УРГАМЛЫН АЙМАГ

Энэ бүс нутаг орших Дорнод Монгол бол Манжуур, Өмнөд Сибирь, Төв Азийн Монгол хошууны хээр ба цөлийн ургамлуудын уулзвар нутаг бөгөөд ургамлын аймгийг нь Оросын болон Монголын эрдэмтэд нэлээд судалсан байдаг. Дорнод Монголын тойрог тус улсын нийт нутаг дэвсгэрийн 8.94 хувьтай тэнцэх бөгөөд энд бүртгэсэн 539 зүйл ургамлаас 60 зүйл (11.13%) нь модлог, 479 зүйл (88.87%) нь өвслөг ургамал болно. Энэ бүс нутгийн хэмжээнд байгалийн гүн хөх, үхэр гонид буюу дэрвээн жиргэрүү, дэрвээн буржгар, гонтог, тарваган шийр, чихэр өвс, зээргэнэ бэриш, ганга, шувуун тарна, алаг башир зэрэг эмийн ургамлын нөөцтэй. Мөн гогод, мангир, тэмээнсүүл, нохойн хошуу, тэхийн шээг, гүйлээс зэрэг хүнсний ургамалтай. Ховор болон нэн ховор ургамлуудын хувьд улаан номонд орсон *Calamagrostis salina* буюу Марцны сорвоо нь Дорнод-Монголын мужлалд бүртэгдсэн

байна.



Зураг 3. Талбайн ургамалжилт

2.8. АМЬТНЫ АЙМАГ

Дорнод аймгийн нутагт 6 баг, 16 овог, 47 төрөлд хамаарах 70 зүйл хөхтөн амьтан байдаг ба үүнээс нэн ховор 6, элбэг тархацтай 3, ердийн тархацтай 30 гаруй зүйл байдаг. Агнуурын ач холбогдолтой зээр, тарвага, шар үнэг, хярс, чоно зэрэг 24 зүйл хөхтөн амьтан байдаг. Онон, Улз, Халхголын сав нутгуудад дэлхийн улаан номд орсон буга, хандгай, баавгай, гахай, ондатр, илбэнх, шилүүс зэрэг 20 орчим зүйлийн ховор амьтдаас гадна бүх нутгаар үнэг, хярс, чоно, дорго, мануул, бор гөрөөс, цагаан зээр, төрөл бүрийн махчин шувууд амьдардаг. Аймгийн хэмжээнд 330 зүйлийн шувуу бүртгэгдээд байна. Үүнээс байнгын суурин байдаг 61, нүүдлийн 262, зусаж өндөглөдөг 212, дайрч өнгөрдөг 66 зүйл шувууд байдаг байна. Мөн дэлхийн болон Монголын улаан номонд бүртгэгдсэн, дэлхийд нэн ховордсон 22 зүйлийн ховор шувууд нутагладаг. Дорнод аймгийн тал хээрийн бүс нь төв азийн цагаан зээрийн өлгий нутаг. Төв азийн цагаан зээрийн 70 хувь нь энд оршин нутагладаг.

2.9. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт орших Хэрлэнтохой XXVIII талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжих газар нь Монгол улсын дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт хамаарахгүй байна.



Зураг 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн байршил

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИХ ҮЕД ХИЙГДЭХ АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

3.1. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Газрын тосны салбарт эдийн засгийн өндөр үр ашигтай олборлолт явуулах, хүрээлэн буй орчинд ээлтэй орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, дотоодын түүхий эдийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах.

3.2. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

“Монголиа Фойсон Энержи” ХХК нь Хэрлэнтохой XXVII талбайд хайгуулын 4+4 жилийн хугацаанд 12000 физик цэгт геологийн хайгуул, 800 тууш км 2 хэмжээст чичирхийлэлийн хайгуул, 600 кв.км талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, хайгуул, үнэлгээний 8 цооног өрөмдөхөөр төлөвлөж байгаа.

2025 онд төслийн талбайдаа 13364 км² талбайд хүндийн хүч болон соронзон хайгуулын аргаар нийт 7318 ширхэг физик цэгт хүндийн хүчний судалгаа, 6738 тууш км талбайд соронзон хайгуулын ажил хийж гүйцэтгэсэн. 2026 онд хайгуулын 1 цооног өрөмдөхөөр төлөвлөж байна.

3.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ МЭДЭЭЛЭЛ


Нийт 32 хүн хээрийн анги дээр байрлан ажиллана. Гэрээт ажилчдыг орон нутаг болон БНХАУ-аас авах бөгөөд хээрийн гэр болон зөөврийн сууцанд байрлуулна. Үүнд:

- Ажилчдын амралтын гэрүүд 8ш
- Бүрэн тоноглогдсон гэр, гал тогоо, бэлтгэлийн гэр, хооллох гэрүүд, хүнсний агуулах
- Зөөврийн сэндвичин хийцтэй сууц 3ш
- Ариун цэвэр, угаалгын контейнер
- Хээрийн тоон боловсруулалт, компьютерийн байр
- Галын цэг, дагалдах тоног төхөөрөмжүүд

3.4. ТӨСӨЛД АШИГЛАГДАХ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ


Өрөмдлөгийн ажлыг БНХАУ-ын мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх бөгөөд компанийн зүгээс өрмийн хаягдлын сангийн бүтээн байгуулалт болон нөхөн сэргээлтийн ажлыг монгол улсын холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Seismic Imaging of Anticline






3D Seismic Image of Channel Sand

Calibrated by Neural Network Analysis of Petrophysical Data



ЦООНОГИЙН ӨРӨМДЛӨГ



Зураг 5. Төслийн үед ашиглагдах техник, технологи

3.5. УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт орших Хэрлэнтохой XXVIII талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхлэх төслийн хүрээнд нийт 2800м урттай 10 ш цооног өрөмдөнө. Цооногийн диаметр нь 273мм байна. Эхний жил 1 ш цооног өрөмдөж, дараах 2-4 дахь жилүүдэд 2 ш, 5 дахь жилд 3 ш цооног өрөмдөхөөр төлөвлөв. Цооног өрөмдөх, өрөмдлөгийн техник технологийг суурилуулах, инженер, үйлчилгээний ажилд нийт 32 ажилчин ажиллана.

Дорнод аймгийн нутаг дэвсгэрт гүйцэтгэх өрөмдлөгийн ажлын үед хээрийн ангийн ажилчдын унд ахуйн хэрэглээний усыг орон нутагтай гэрээ байгуулан сумын төвөөс зөөвөрлөн хэрэглэхээр төлөвлөж байна. Харин унд ахуйн усны хэрэглэг худалдааны усаар хангах юм. Өрмийн анги болон хайгуулын ангид нийт 32 ажиллагсад ажиллана.

Унд-ахуйн усны тооцоо: Унд ахуйн усны хэрэгцээг тооцохдоо Монгол улсын БОНХАЖЯСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тушаалын дагуу “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”-ын дагуу “Худаг, булаг зэрэг зөөврөөр хангагддаг гэр хороолол” нэг хүний өдөрт ашиглах усны хэмжээ 20 л/хоног байхаар тооцов.

Хүснэгт 1. Усны хэрэглээ

№	Ажил үйлчилгээний нэр	Норм хэмжээ	Хэмжих нэгж	Хоногийн хүчин чадал	Тайлбар	Усны хэрэглээ, м³/хоног	Жилд ажиллах хоног/тоо	Усны хэрэглээ м³/жил
1	Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц	150	л	32	Ажилчдын ус хэрэглээ (л/хон)	4.80	90	432.00
2	Шавар уусмалаар цооног цэвэрлэх (Цүүцний голч 300)	44	м³	1	Цооног цэвэрлэх хэрэглээ м³/100м	44.00	90	3,960.00
	Нийт					48.8		4,392.0

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

4.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тоосжилт, тоосонцор байна. Хайгуулын талбай байрлаж буй хэсэг нь хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй бүс бөгөөд ургамлан бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсэх боломжтой юм.

Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим нь: Судалгааны ажлын үед өрмийн цамхаг зөөвөрлөх хүнд даацын машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсч, салхи, шуургаар дамжин тархах магадлалтай.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Хайгуулын ажлын үед тухайн орчинд тоосжилт үүсэх бөгөөд энэ нь агаар орчинд төдийгүй талбай орчмын зэрлэг амьтан, мал, ургамлан бүлгэмдэл, хайгуулын ажилчид болон хайгуулын талбайн ойр амьдрах хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Үргэлжлэх хугацаа: Агаар мандлын бохирдол нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд богино хугацаанд буюу тоног төрөөрөмжийн тээвэрлэлтийн үед үүснэ. Харин өрөмдлөгийн ажлын үед шууд нөлөөлөл бага байна.

4.2. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хайгуулын талбай орчмын хөрс нь шим тэжээлийн түвшингээр тааруу, ялзмагийн агууламж бага элсэнцэр, элсэрхэг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учир элэгдэл эвдрэлд орохдоо амархан хөрс юм.

Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим: Хайгуулын ажил хийх, зам шинээр гаргах, кэмп байгуулах, цооног өрөмдөх үйл ажиллагаанаас болж хөрс эвдэрч элэгдэлд орно. Хайгуулын ажилд ашиглагдаж байгаа машин механизмын хөдөлгөөнөөр хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсч хөрс эвдрэх магадлалтай.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Хайгуулын үйл ажиллагаанаас тухайн орчмын газар болон машин замын ойролцоо газруудад хөрсний элэгдэл үүсэж, ургамлан нөмрөгийн зүйлийн бүрдэл буурах, амьтад даажих зэрэг нөлөөллүүд үүсэж болзошгүй. Мөн хөрсөнд шатах тослох материалын асгаралтаас үүдээд хөрс өөрийгөө цэвэршүүлэх, сэргээх чадвар алдагдах эрсдэлтэй.

Үргэлжлэх хугацаа: Цооног өрөмдөхөөс бусад хайгуулын ажлын үе шатанд хөрсний элэгдэл эвдрэл нь богино хугацаагаар үргэлжилнэ. Харин газрын тосны зориулалтаар өрөмдсөн цооногийн хаягдлын сангийн хөрс хүчтэй бохирдох бөгөөд өөрийгөө нөхөн төлжүүлэх чадвар харьцангуй удаан байдаг.

4.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Өрмийн шингэн хаягдлын сангаас, ахуйн хог хаягдал хаях, шатах тослох материал хөрсөнд асгарах тохиолдолд хөрсний усыг бохирдуулах боломжтой.

Үргэлжлэх хугацаа: Хөрсөнд нэвчсэн тохиолдолд хорт бодис нь гүний усанд уусч удаан хугацаагаар хадгалагдана.

4.4. АМЬТАН, УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хайгуулын үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлан нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй.

Мөн олон салаа зам үүсэн тохиолдолд дэгдэх тоосны нөлөөнд өртсөн ургамлын зүйлийн дотоод бүтэц, физиологийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Хайгуулын чичирхийллийн судалгааны үед амьтан үргэх, даажих магадлалтай юм.

БҮЛЭГ 5. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2026 онд “Хэрлэнтохой” талбайд хамаарах хотгор орчимд 1 цооног өрөмдөхөөр төлөвлөж байна.

Иймд төслийн хүрээнд байгаль орчныг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэхэд дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:

- Төслийн хайгуулын ажлын явцад зам ашиглалтын байдалд тогтмол хяналт тавих, олон салаа зам гаргахгүй байх
- Түр кемпийн ашиглалт, зохион байгуулалтын ажлыг байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар хийж ашиглах
- Хог хаягдлын нэгдсэн менежментийг боловсруулан ажиллах
- Химийн бодисын ашиглалт, хадгалалтын горимыг мөрдөн ажиллах
- Хог хаягдлыг шатаах зуухтай болох
- Өрмийн шингэн хаягдлын санг MNS 6200:2010 стандартын дагуу хийх
- Өрөмдсөн цооногийн талбайн нөхөн сэргээлтийг MNS 6200:2010 стандартын дагуу хийх
- Шугамын ажил явагдсаны дараа хог хаягдлыг цэвэрлэх, нөхөн сэргээлтийн ажлыг хийж орон нутагт хүлээлгэн өгөх
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ус, хөрсний хяналт шинжилгээ, хэмжилтийг гүйцэтгэх
- Төслийн хүрээнд ажил гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын байгаль орчны үйл ажиллагаанд хяналт тавих
- Нийт ажилчдад байгаль орчны сургалт, сурталчилгааг явуулах

БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрс									
	Машин механизмаас ялгарах ШТМ-ын хаягдлаар хөрс, ургамал бохирдох	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Хайгуулын талбай	ш	3,000,000	1	3,000,000	Үйл ажиллагааны турш	
		Хөрсний шинжилгээг ОХШХ-т заасан хугацаанд хийлгэх	Хайгуулын талбай					ОХШХ-ийн зардлаар	
	Тээврийн хэрэгслээр олон салаа зам үүсч хөрс эвдрэх	Олон салаа зам гаргахгүй байх үүднээс төслийн хүрээнд явах замын маршрутыг гаргаж жолооч ажилчдад мэдэгдэн, зөвлөмж хүргүүлж байх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах /5 тэмдэг худалдан авах, байршуулах/	Хайгуулын талбай	ш	280,000	5	1,400,00	8 сард	
	Ахуйн хатуу хог хаягдлаар хөрс бохирдох	Хатуу хог хаягдал, ахуйн химийн бодисын эмх цэгцтэй хадгалах	Төслөөс ялгарах хог хаягдал	ш	1,000,000	2	2,000,000	Төсөл хэрэгжихээс өмнө, 8 сард	

**“Монголиа Фойсон Энержи” ХХК-ийн “Хэрлэн тохой ХХVIII” хайгуулын талбайд
бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын ажил гүйцэтгэх төслийн
2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Ажилчдаас үүсэх ахуйн шингэн бохироор хөрс бохирдох	Септиктэй био бичил цэвэрлэх байгууламж байгуулах	Кемп	ш	8,000,000	1	8,000,000	Төсөл хэрэгжихээс өмнө, 8 сард	
	Ус эргэлтийн сан байгуулах	Ус эргэлтийн санг байгуулахын өмнө шимт хөрсийг хуулан авч тустай овоолго үүсгэн хадгалах	Хайгуулын цооног өрөмдлөг	м²	8,250	24	198,000	Цооног өрөмдлөг эхлэхээс өмнө	MNS 5916:2008 MNS 5917:2023
		Гиомембран дэвсэх*	Хайгуулын цооног өрөмдлөг	м²	120,000	250	30,000,000	Цооног өрөмдлөг эхлэхээс өмнө	
Агаар									
	Агаарын бохирдлоос сэргийлэх	Машин механизмын түлшний шаталтыг бууруулах дэвшилтэт технологи хэрэглэх	Төслийн хугацаанд хэрэглэх техник хэрэгсэл	ш	250,000	4	1,000,000	Үйл ажиллагаан турш, 8 сард авах	MNS 4585:2007 MNS 5014:2003
Ургамал									
	Ургамлан нөмрөг хамгаалах	Хайгуулын талбай, цооног өрөмдсөн газруудад олон наст ургамлын үр тариалж ургамалжуулах, орчныг тохижуулах, мод бут, сөөг тарих	Хайгуулын талбай орчим	Нөхөн сэргээлтийн зардал				10 сард	MNS 5917:2008 MNS 5914:2023

**“Монголиа Фойсон Энержи” ХХК-ийн “Хэрлэн тохой ХХVIII” хайгуулын талбайд
бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын ажил гүйцэтгэх төслийн
2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Машин механизмаас ялгарах ШТМ-ын хаягдлаар хөрс, ургамал бохирдох	Асгарсан бодисыг цуглуулах иж бүрдлийг машин техникт ашиглах байршуулах, зааврыг өгөх	Машин техникүүд	ш	750,000	2	1,500,000	8 сард	
	Усны нөөцөд нөлөөлөх	Усны тайлан боловсруулан нутгийн БО байцаагч, усны мэргэжилтэнд мэдэгдэж, усны төлбөр төлөх	Төслийн усны хэрэглээ	ш	300,000	1	300,000	9 сард	
		Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл авах, гэрээ байгуулах	Усны хэрэглээ	ш	50,000	1	50,000	9 сард	
		Төлөвлөсний дагуу Технологийн усыг хэмнэлттэй ашиглах төхөөрөмж, усан сан байгуулах	Цооног өрөмдөх технологи	ш	-	1	Хөрөнгө оруулалтын зардал	8 сард	
		Хаягдал усны дүгнэлт авах/ улирал бүр	Төслийн усны хэрэглээ, шингэн бохир	ш	300,000	2	600,000	8, 10 сард	
	Газрын тосны бүтээгдэхүүнээс цацраг идэвхи ялгарч болзошгүй	Газрын тосны бүтээгдэхүүнээс цацрагийн шинжилгээ хийлгэх	Газрын тосны бүтээгдэхүүн	ш	300,000	1	300,000	9 сард	-
Нийт зардал			48,348,000						

Тэрбум модны хөдөлгөөн

5000 ширхэг модыг Дорнод аймгийн Матад сумын нутагт, 5000 ширхэг модыг Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын төвд салхинаас хаах зурвас байдлаар тарилт хийнэ. Тарилтыг нутгийн иргэдтэй хамтран гүйцэтгэнэ.

Хүснэгт 3. Тэрбум модны хөдөлгөөний ажлыг гүйцэтгэх зардлын тооцоо

№	Арга хэмжээ		Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тэрбум модны хүрээнд жил бүр 5000 мод тарих	суулгац	ш	5,000	10,000	50,000,000	Жил бүр	MNS 6141:2020 MNS 6256:2011 MNS 6255:2011 MNS 6258-2:2011
		Тарилт хийх	ш	8,400	10,000	84,000,000	Жил бүр	
Нийт						134,000,000		

БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Цооног өрөмдөх явцад эвдэрсэн газрыг цооног өрөмдөж дуусны дараа цооногийн өрөмдлөгт хэрэглэсэн эргэлтийн усан санд нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ.

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоо

№	Арга хэмжээ	Цар хүрээ, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Эргэлтийн усан сан нөхөн сэргээх	20м*3м*3м	ш	3,008,800	1	3,008,800	10 сард	MNS 6260:2020 MNS: 5918:2023
	Нийт					3,008,800		

БҮЛЭГ 8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах	Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон талбайд зэрлэг амьтдад зориулсан орчин үеийн технологиор тоноглогдсон бүрэн автомат ажиллагаатай хөв цөөрмийг шинээр 1 цэгт байгуулах	“Дорнод Монгол”-ын ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	1	4,000,000.0	4,000,000.0	9 сард	
	Нийт					4,000,000.0		

БҮЛЭГ 9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

2026 оны хайгуулын ажил гүйцэтгэх талбайд нөлөөлөлд өртөх, ямар нэгэн нөхөн олговор олгох орон нутгийн айл одоогоор байхгүй болно. Өрөмдлөгийн хайгуулын цэг тодорхой болоогүй байгаа. Хэрэв төслийн талбай дээрх айл өрхтэй хайгуулан өрөмдлөг хийх цэг давхцвал нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлнэ. Өрөмдлөгийн цэгтэй давхцсан тохиолдолд техникийн хувьд боломжтой бол өрөмдлөгийн цэгийг бага зайгаар шилжүүлж, айлын ашиглаж буй газар, байгууламжаас зайлсхийх эсүл тусгай зөвшөөрөлтэй компаниар үнэлгээ хийж хохиролыг тодорхойлон нөхөн олговор олгоно.

БҮЛЭГ 10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн хайгуулын талбайд 2025 онд Шинжлэх ухааны академи Археологийн хүрээлэнгээр судалгаа хийлгэсэн.

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрт хайгуул хийж байх явцад соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу эртний түүхийн гэрч болох дурсгалт хөшөө бунхан, хиргэсүүр, археологи, палентологийн ховор олдворт зүйлс илэрсэн тохиолдолд МУ-н соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал, /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйл ажиллагааны явцад түүх дурсгалын ямар нэгэн олдвор илрэх	Нийт ажилчдад “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ыг хэрэгжүүлэх тухай сургалтыг явуулах*	Нийт ажилчдад	1	300 000		Хайгуулын ажлын явцад	“Санамсаргүй олдворын үед ажиллах журам” болон Соёлын өвийн тухай хууль
Нийт					300 000			

*үйл ажиллагааны зардал

БҮЛЭГ 11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Хайгуулын ажиллагсадын эрүүл мэнд, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхэд оршино.

Хүснэгт 7. Осол эрсдэлээс үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Технологийн гаралтай осол эрсдэл	Нийт ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг хамгаалах талаар сургалтад хамруулах (жилд 1 удаа, 600.0 мян.төг)	Хайгуулын нийт ажилчид	1	600,000	600,000	9 сард	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2		Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах	Хайгуулын нийт ажилчид	1	500,000	500,000	8 сард	
3		Ажлын байр, зам талбайд ХХАА-ны ба замын хөдөлгөөний дүрмийн дохио, санамжуудыг хийж тавих	Хайгуулын нийт ажилчид	5	200,000	1,000,000	Хайгуулын ажлын турш	
4		Ослын үед ажиллах ИТА, ажилчидын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	Хайгуулын нийт ажилчид	1	200,000	200,000	Хайгуулын ажлын турш	
5		Ажиллагсадыг улиралд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	Хайгуулын нийт ажилчид	32	500,000	16,000,000	10 сард	
6		Ажиллагсадыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр бүрэн хангах	Хайгуулын нийт ажилчид	32	1,200,000	38,400,000	Хайгуулын ажлын турш	
7	Байгалийн гаралтай осол, эрсдэл	Тал хээрийн түймэр унтраах машин, техник багаж хэрэгсэл, хүн хүчтэй байх, гал түймрээс хамгаалах хэрэгсэлээр хайгуулын талбайн кемп болон ажлын байрыг хангах арга хэмжээг авах	Хайгуулын нийт ажилчид	1	1,000,000	1,000,000		

**“Монголиа Фойсон Энержи” ХХК-ийн “Хэрлэн тохой ХХVIII” хайгуулын талбайд
бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын ажил гүйцэтгэх төслийн
2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
8		Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажиллагсдын дунд сургалт жилд 1 удаа зохион байгуулах	Хайгуулын нийт ажилчид	1	500,000	500,000		
9		Аваар устгах төлөвлөгөө боловсруулан батлуулах	Төслийн хүрээнд	1	600,000	600,000		
Нийт зардал						58,800,000		

БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Зорилго: Үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино.

Компаний хэмжээнд мөрдөгдөж байгаа “Хог хаягдлын менежментийн журам”-г дагаж мөрдөнө.

Хүснэгт 8. Хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

Д/д	Хог хаягдлын ангилал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг, төг	Тоо хэмжээ	Нийт өртөг, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгах талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх	Хайгуулын ажилчид	ш		1	20,000	8 сард	Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдлын цэг орчмыг тогтмол цэвэрлэж арчлах, ариутгах	Хог хаягдлын түр цэг орчим	ш	100,000	1	100,000	8 сард	
3		Дахивар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Хайгуулын ажлын хүрээнд	ш	130000	1	130,000	9 сард	
4		Энгийн хог хаягдлыг Дорнод аймгийн Матад сумын засаг даргатай Хог хаягдал цуглуулах, тээвэрлүүлэх үйлчилгээний гэрээ байгуулж зайлуулах	Хайгуулын ажлын хүрээнд	ш	165000	9	1,485,000	Сар бүр	
5	Автомашинаас ялгарах аюултай	Машин техникээс ялгарах аюултай хог хаягдлыг ялган стандартын дагуу шошго тэмдэг тавиж, бороо, усны нөлөөгөөр тархах, ажилчдад сөрөг нөлөө үзүүлэхгүй тусгаарлагдсан орчинд хадгалах	Хайгуулын ажлын хүрээнд	ш	200,000	1	200,000	Сар бүр	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
6		Машин техникээс ялгарах аюултай хог хаягдал тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан	Хайгуулын ажлын хүрээнд	ш	200000	2	400,000	Тухай бүр	

**“Монголиа Фойсон Энержи” ХХК-ийн “Хэрлэн тохой ХХVIII” хайгуулын талбайд
бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын ажил гүйцэтгэх төслийн
2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Д/д	Хог хаягдлын ангилал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг, төг	Тоо хэмжээ	Нийт өртөг, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт
		нийлүүлэх							MNS 6487:2014
7	Үйлдвэрийн хог хаягдал	Өрмөнд хэрэглэх химийн бодисны үлдэгдэл, сав баглаа боодлын хог хаягдлыг Эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Хайгуулын ажлын хүрээнд	ш	20,000,000	1	20,000,000	улирал бүр	MNS 6458:2014
8		Хаягдал тосыг тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан зайлуулах	Хайгуулын ажлын хүрээнд	ш	1,000,000	1	1,000,000	улирал бүр	
9		Хаягдал тос хадгалах байгууламж байгуулах ба төлөвлөгөө боловсруулан эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан устгуулна.	Хайгуулын ажлын хүрээнд	ш	50,000,000	1	50,000,000	улирал бүр	
	Нийт зардал				-		78,415,000		

БҮЛЭГ 13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Зорилго: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хяналтын цэгүүдэд, хуваарийн дагуу хийж үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг хянах, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино. Хайгуулын талбайн хүрээнд үйл ажиллагаа явуулах үед мэргэжлийн байгууллагаар ОХШХ-г гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 9.2026 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн давтамж, зардал

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, төг/дээж	Зардал, төгрөг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаар					
SO ₂ , NO ₂ , CO, Тоос	тосгон орчим, өрөмдлөгийн цооногийн орчим 3 цэгт	Жилд 3 удаа, хавар, намар	140,000	840,000	MNS 4585:2025
Дуу шуугиан	тосгон орчим, өрөмдлөгийн цооногийн орчим 3 цэгт	Жилд 3 удаа, хавар, намар	20,000	40,000	MNS 5002:2000
Хөрс					
Хөрсний хүнд металлын бохирдол	Машины зогсоол, засварынцэг, цооног өрөмдөх үйл ажиллагаа явагдаж байгаа газар 4-- 6 цэгт	Жилд 3 удаа	130,000	1,560,000	MNS 3297:2019
Хөрсний агрохимийн шинжилгээ	Контрол цэг	Жилд 1 удаа	60,000	60,000	
Ус					
Худгийн ус	Төслийн талбайд	Жилд 3 удаа	300,000	900,000	MNS 0900:2018
	Хаягдал ус	Жилд 3 удаа	150,000	450,000	
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн				3,850,000	

БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орон нутгийн иргэд болон төрийн байгууллагыг үнэн зөв бодит мэдээллээр хангахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Үүнд:

- Орон нутгийн иргэдтэй уулзаж хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээллийг хүргэж байх
- Төрийн байгууллагуудад журмын дагуу тайлангийн биелэлт, гүйцэтгэлийг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх (Тухайн цаг хугацаанд)
- Бусад үед шаардлагатай мэдээ, судалгааг гаргаж төрийн байгууллагуудад хүргүүлэх (Тухайн цаг хугацаанд)

Хүснэгт 10. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга-	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Дорнод аймгийн Матад сумын ЗДТГ, байгаль орчны хяналтын улсын байцаагч	Талбай дээр	Кемпийн газар болон хайгуулын талбайн нөхөн сэргээлтийг газар дээр нь танилцуулж, талбайг хүлээлгэн өгөх ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А50/А31 тоот хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтын дагуу нөхөн сэргээх ажлыг хүлээн авсан тухай баримт үйлдэх	Хайгуулын ажил дууссаны дараа	-	Байгаль орчны мэргэжилтэн, Газрын тосны мэргэжилтэн	“Монголиа фойсон энерги” ХХК
2	Дорнод аймгийн БОАЖГ	БОМТ-ний биелэлтийн тайлан	2019.10.29 № А/618 “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу биелэлтийн тайлан гаргах	Хайгуулын ажил дууссаны дараа	-	Байгаль орчны мэргэжилтэн, Газрын тосны мэргэжилтэн	“Монголиа фойсон энерги” ХХК
3	БОУАӨЯ	БОМТ-ний биелэлтийн тайлан		Хайгуулын ажил дууссаны дараа	-	Байгаль орчны мэргэжилтэн, Газрын тосны мэргэжилтэн	“Монголиа фойсон энерги” ХХК
4	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Илтгэл, танилцуулга	Нийт хийгдсэн ажлуудын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	10 дугаар сард	1000.0	Компаний удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн	“Монголиа фойсон энерги” ХХК

БҮЛЭГ 15. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ НИЙТ ЗАРДАЛ

2026 оны байгаль орчныг хамгаалах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт **341,421,800** төгрөг зарцуулна.

Үзүүлэлт	2026
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	48,348,000
Биологийн нөхөн сэргээлт	3,008,800
БОЯБ дүйцүүлэн хамгаалах	4,000,000
Тэрбум мод үндэсний хөдөлгөнө	134,000,000
Нүүлгэн шилжүүлэлт	-
Түүх соёлийн өв хамгаалах	10,000,000
Осол эрсдэл, удирдлага зохион байгуулалт	58,800,000
Хог хаягдал	78,415,000
ОХШХ	3,850,000
БОМТ тайлагнах	1,000,000
Нийт	341,421,800

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах хууль тогтоомж, журам, стандартууд мөрдөн ажиллана. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль
- Усны тухай хууль
- Агаарын тухай
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Амьтны тухай хууль
- Газрын тухай
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам
- Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм тогтоож тэмдэгжүүлэх журам
- Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025
- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5918:2023
- Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015
- Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018

БОМТ-ний хавсралт материалууд

1. “Монголиа Фойсон Энержи” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /Газрын тос хайх/
3. 2026 оны ажлын үр дүнг орон нутаг дүгнэсэн актууд
4. Материалуудыг хуулбарласан CD